

ЕСҮС ХРИСТИЙН САЙН МЭДЭЭ





ЕСҮС ХРИСТИЙН САЙН МЭДЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?

Есүс Христийн сайн мэдээ бол Өөрийнхөө хүүхдүүдийн аз жаргал хийгээд **авралд*** зориулсан Тэнгэрлэг Эцэгийн маань төлөвлөгөө юм. Есүс Христийн **Цагаатгал** энэхүү төлөвлөгөөний гол цөм нь учраас үүнийг Есүс Христийн сайн мэдээ хэмээн нэрлэдэг. Утга учиртай, аз жаргалтай амьдарлаар амьдарч, энэ амьдралынхаа дараа мөнхийн баяр баясгаланг мэдэрч болохыг үзүүлэхийн тулд Өөрийнхөө төлөвлөгөөний дагуу Тэнгэрлэг Эцэг Өөрийн Хүү Есүс Христийг энэ дэлхий уруу илгээсэн юм. Есүс Христийн **ач ивээл** хийгээд нигүүлслийн дагуу та нүглээс ангижирч, сэтгэлийн амар амгаланг эдэлж чадна. Энэ амьдралынхаа дараа Тэнгэрлэг Эцэгийн дэргэд амьдрахад та зохистой болж чадна.

Энэхүү амар амгалан, хүч чадлыг хүлээн авахын тулд та сайн мэдээний зарчмууд болон **ёслолуудыг** сурч мөн дагах ёстой. Зарчим бол энэ амьдралд ашиглагддаг үнэн юм; ёслол бол санваарын эрх мэдлээр гүйцэтгэгддэг нандин, албан ёсны үйлдэл бөгөөд ихэнхдээ Тэнгэрлэг Эцэгтэй **гэрээ** хийх гэсэн утгатай. Сайн мэдээний анхны зарчмууд нь Есүс Христэд итгэх итгэл мөн наманчлал юм. Сайн мэдээний анхны ёслолууд нь **баптисм** мөн Ариун Сүнсийг хүлээн авах нь юм.

Сайн мэдээний анхны зармууд хийгээд ёслолуудыг сурч мөн дагаснаар та үлдсэн амьдралынхаа турш Христийн жишээг дагахаар хичээх болно. Ийнхүү үргэлж итгэлтэй байхыг “эцсээ хүртэл тэвчих” гэж нэрлэдэг.

Доорх зүйлсийг хийснээр та Есүс Христийн сайн мэдээгээр амьдарч чадна:

- *Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлж.*
- *Наманчилж.*
- *Баптисм хүртэж, Ариун Сүнсийг хүлээн авч.*
- *Эцсээ хүртэл тэвчсэнээр.*

*Улаанаар бичигдсэн үгсийг хуудас 18, 19-д тайлбарласан болно.

ЕСҮС ХРИСТЭД ИТГЭХ ИТГЭЛ

Итгэл бол хүнийг үйлдэл уруу хөтөлдөг хүчтэй итгэл үнэмшил юм. Нүглүүдийн өршөөл уруу хөтөлдөг итгэл Цагаатгал нь өршөөлийг боломжтой болгосон Есүс Христэд төвлөрдөг. Есүс Христэд итгэх итгэл бол Түүнд итгэх үлбэгэр сүсэг бишрэлээс хавьгүй илүү юм. Энэ нь Тэр бол та нарын нүгэл, зовлон зүдгүүр, сул дорой байдлын төлөө зовсон Бурханы Хүү

гэдэгт итгэх итгэлийг хэлдэг. Энэ нь тэрхүү итгэлийг үйл хөдлөл болгох гэсэн утгатай юм. Түүнийг хайрлаж, Түүнд итгэж, Түүний зарлигуудыг дуулгавартай дагах зам уруу Есүс Христэд итгэх итгэл таныг хөтөлдөг.

“Бүх зүрхээрээ Эзэнд итгэ; өөрийн ойлголтод бүү түшиглэ.

“Өөрийн бүх замаараа Түүнийг таньж мэд, Тэр чиний замыг шулуун болгоно.”

Сургаалт үгс 3:5–6

НАМАНЧЛАЛ

Есүс Христэд итгэх итгэл нь таныг амьдралаа илүү сайн болгож өөрчлөх зам уруу хөтөлдөг. Сайн мэдээг судалснаар та нүгэл үйлдсэн боло-

хоо буюу Бурханы таалал хийгээд заасан зүйлсийн эсрэг үйлдсэнээ ухаарах болно. Наманчлалаар дамжуулан, та Бурханы заасан зүйлстэй нийцдэггүй тэдгээр бодол, хүсэл, дадал, мөн үйл хөдлөлүүдээ өөрчилж чадна. Хэрэв наманчлах юм бол, таны нүглүүдийг өршөөнө хэмээн Тэр амладаг. Наманчлахдаа та:


Нүгэл үйлдсэнээ **ухааран ойлгож**, өөрийнхөө хийсэн зүйлд үнэн голоосоо харамсах болно.

Буруу зүйл хийхээ **больж**, дахин хийхгүй байхаар хичээнэ.

Нүгэл үйлдсэнээ Их Эзэнд **хүлээн зөвшөөрч** өршөөл эрнэ. Ийн үйлдсэнээр, таны хүнд ачаа хөнгөрөх болно. Хэрэв хэн нэгэнд нүгэл үйлдсэн бол, та түүнчлэн тэр хүнээс өршөөл эрэх ёстой.

Есүс Христэд итгэх итгэл бол сайн мэдээний анхны зарчим юм.





Буцааж өгөх. Үйлдлийн тань улмаас гарсан асуудлыг засахын тулд та чадах бүхнээ хий.

Зарлигуудыг сахь. Бурханы зарлигуудыг сахих нь таны амьдралд сайн мэдээний хүч чадлыг авчирдаг. Нүглүүдээ орхих хүч чадлыг сайн мэдээ танд өгөх болно. Үйлчлэл үзүүлэх, бусдыг уучлах, Сүмийн цуглаануудад оролцох зэрэг нь зарлигуудыг сахихад багтдаг.

Аврагчийг таньж мэд. Есүс Христийн учир өршөөл ирсэн гэдгийг ухаарах нь наманчлалын хамгийн чухал хэсэг юм. Ноцтой нүглүүдийг Бурхан хэзээ ч өршөөхгүй хэмээн зарим үед та боддог байж болох юм. Гэвч Аврагч бидний нүглүүдийн төлөө зовсноор бүр ноцтой нүглүүд ч бидний ард хоцордог. Жинхэнэ наманчлалын үр дүн бол өршөөл, амар амгалан, тайтгарал, мөн баяр баясгалан юм.

Наманчлал гэдэг нь үргэлж том өөрчлөлт хийх гэсэн үг биш юм. Бурханы тааллын дагуу амьдрах амлалтаа чанаржуулахыг ихэнхдээ энэ нь шаарддаг. Жинхэнэ наманчлал үргэлж тэр даруй болчихдоггүй; зөвийг хийж, гаргасан алдаа дутагдлаа засахаар хичээх үедээ тэвчээртэй бай.

Наманчилснаар та зүрх сэтгэлийн өөрчлөлтийг мэдэрч чадна. Нүгэл үйлдэх хүсэл танд дахин төрөхгүй байх болно. Би бол Бурханы хүүхэд, нэг гаргасан алдаагаа дахин дахин давтах хэрэггүй юм гэдгийг та ойлгох болно. Бурханыг дагах таны хүсэл улам илүү хүчтэй гүн өсөх болно.

Бид бүгдээрээ алдаа гаргадаг. Заримдаа бид өөрсдийгөө гэмтээж, мөн өөрөө ганцаараа засч залруулж чадахааргүйгээр бусдад ноцтой гэмтэл учруулдаг. Бид дан ганцаараа засч чадахгүй тийм зүйлийг эвдэлдэг. Тэгээд бид дан ганцаараа анагааж чадахгүй гэмтэй сэтгэгдэл, басамжлал, сэтгэлийн шаналлыг мэдэрдэг. Бидний засч чадахгүй тэрхүү зүйлийг Цагаатгалын анагаах хүч тэр даруй анагааж чадна.

БАПТИСМ БА АРИУН СҮНС

Есүс Христэд итгэх итгэл, наманчлал хоёр таныг баптисм, Ариун Сүнснийг хүлээн авах хоёрт бэлтгэдэг. Нүглүүдийн ангижрал хийгээд өршөөлийн төлөө хүн бүхэн ус болон Сүнсний (Ариун Сүнс) баптисм хүртэх ёстой хэмээн Есүс Христ заажээ. Санваарын эрх мэдэл бүхий нэгнээс баптисм хүртэж, Ариун Сүнснийг хүлээн авснаар та сүнслэг байдлаараа дахин төрөх болно.

Би яагаад баптисм хүртэх шаардлагатай юм бэ?

“Бүх зөв шударгыг гүйцэлдүүлэхийн тулд” баптисм хүртсэнээр Есүс Христ бидэнд үлгэр жишээ болсон юм (Матай 3:15). Баптисм хүртсэнээр та нүглүүдийнхээ ангижралыг хүлээн авдаг (Үйлс 2:38-ыг үз). Есүс Христийг Аврагчаа хэмээн хүлээн зөвшөөрч, Түүнийг дагаж, мөн Түүний зарлигуудыг сахина хэмээн та Бурхантай гэрээ буюу амлалт хийдэг. Хэрэв та өөрийнхөө амлалтыг биелүүлбэл, нүглүүдийг тань өршөөнө хэмээн Тэнгэрлэг Эцэг тань амладаг. Зөв эрх мэдлээр баптисм хүртсэнээр таны нүглүүд угаагдах болно.

*“Есүс, Үнэнээр,
үнэнээр, би чамд хэлье,
хэн ус болон Сүнснээс эс
төрнө, тэр хүн Бурханы
хаанчлалд орж чадахгүй.”*

Иохан 3:5

Усанд түр зуур дүрэгдэх нь баптисмд багтдаг. Есүс Христ мөн ингэж баптисм хүртсэн билээ. Усанд умбуулалтаар хийгддэг баптисм нь Есүс Христийн үхэл, оршуулалт, мөн амилуулалтын нандин бэлэгдэл юм; энэ нь таны хуучин амьдрал төгсөж, Есүс Христийн дагалдагчийн хувьд таны шинэ амьдралын эхлэлийг бэлэгддэг.

Би яагаад Ариун Сүнснийг хүлээн авах шаардлагатай вэ?

Баптисм таны нүглүүдийг угаадаг бол, Ариун Сүнс таныг ариусгаж мөн цэвэршүүлдэг. Хэрэв та баптисмынхаа гэрээ нүүдэд итгэлтэй хэвээр байх юм бол, Ариун Сүнс тантай



үргэлж хамт байж чадна. Бүх сайн хүмүүс ариун сүнсний нөлөөг мэдэрч чадах боловч, баптисм хүртэж, Ариун Сүнснийг хүлээн авах хүн амьдралынхаа турш Ариун Сүнстэй хамтрагч байх эрхтэй байдаг.

Үнэнийг танин мэдэж, ойлгоход тань Ариун Сүнс танд тусалдаг. Тэрээр сүнслэг хүч чадал хийгээд сүнслэг удирдамжаар хангадаг. Хүнд хэцүү цагт тань тэр таныг тайтгаруулж, шийдвэр гаргахад тань таныг чиглүүлэх болно. Ариун Сүнсээр дамжуулан та Бурханы хайр хийгээд нөлөөг амьдралынхаа турш мэдэрч чадна.

Ариун Сүнс танд зааж,
мөн таныг хөтөлж чадна.

*“Харин Туслагч буюу
Миний нэрээр Эцэгийн
илгээх Ариун Сүнс
та нарт бүх зүйлсийг
заах бөгөөд Миний та
нарт хэлсэн бүгдийг
сануулах болно.”*

Иохан 14:26

Бурханы зарлигуудад хэр дуулгавартай байснаас тань энэхүү бурханлиг бэлгийг хүртэх боломж тань хамаарна. Бурханы заасан зүйлсийн дагуу амьдардаггүй хүмүүстэй Ариун Сүнс үлдэж чадахгүй. Түүний заавар хийгээд бурханлиг удирдамжийг тэд алддаг. Ариун Сүнсний чиглүүлэл хийгээд нөхөрлөлд зохистой байхыг үргэлж хичээ.

Баптисмын дараа та Ариун Сүнснийг хүлээн авах болно. Нэг буюу хэд хэдэн санваарын эрх мэдэл бүхий хү-

мүүс таны толгой дээр гар тавин адислах ёслолыг **гишүүний баталгаа** хэмээн нэрлэдэг. Тэд таныг Сүмийн гишүүнээр баталж, Ариун сүнснийг хүлээн ав хэмээн адисалдаг. Энэхүү ёслол нь ихэвчлэн баптисмын дараахан сүмийн үйлчлэл дээр болдог. Баптисм хүртэж, сүмийн гишүүнээр батлагдсанаар та Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн болдог.

**Улаанаар бичигдсэн үгсийг хуудас 18, 19-д тайлбарласан болно.*

Ариун Сүнснийг гар тавилтаар өгдөг.





Ариун ёслол

Баптисм хүртсэнийхээ дараа, ариун ёслолоос хүртсэнээр та долоо хоног бүр баптисмынхаа гэрээг шинэчилж чадна. Ариун ёслолын үйлчлэлийн үеэр, Есүс Христийн Цагаатгалын сануулга болгон талх, усыг адисалж, оролцогчдод түгээдэг. Талх нь Есүс Христийн биеийг төлөөлдөг бол, ус нь Түүний цусыг төлөөлдөг. Баптисмынхаа гэрээг шинэчилснээр та Сүнс буюу Ариун Сүнсийг үргэлж өөртэйгөө хамт байлгана хэмээн амладаг.

*Есүс Христийн амьдрал,
тохинуулал мөн
Цагаатгалыг талархал-
тайгаар дурсан санахад
ариун ёслол танд
тусалдаг.*

*Улаанаар бичигдсэн үгсийг хуудас 18, 19-д тайлбарласан болно.

Есүс Христийг дурсан санахад ариун ёслол бидэнд тусалдаг.

ЭЦСЭЭ ХҮРТЭЛ ТЭВЧИХ НЬ

Есүс Христэд итгэх итгэл, наманчлал, баптисм хийгээд гишүүний баталгааны ёслолуудаар дамжуулан та Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн болдог. Сүмийн гишүүн болсны дараа таны ойлголт цаашид улам өсөх болно. Тэгээд та Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлж, наманчилж, ариун ёслолоос хүртсэнээр баптисмынхаа гэрээг шинэчилж, мөн Ариун Сүнсний зааварчилгааг дагах болно. Сайн мэдээний энэхүү анхны зарчим хийгээд ёслолууд нь амьдралынхаа турш дагаж мөрдөх загвар юм. Амьдралын турш дагаж мөрдөнө гэсэн энэхүү амлалтыг ихэвчлэн “эцсээ хүртэл тэвчих” хэмээн нэрлэдэг.

Эцсээ хүртэл тэвчих нь амьдралд чиглүүлэл, амар амгалан, аз жаргалыг авчирдаг. Өөрийнхөө эргэн тойронд байгаа хүмүүст үйлчилж, тэдэнд тусалснаар та Есүс Христтэй адил болохыг хичээхийн баяр хөөрийг мэдрэх болно. Ингэснээр та Тэнгэрлэг Эцэгтэйгээ харьцах харьцаагаа илүү сайн ойлгож, таныг хайрлах Түүний төгс хайрыг мэдрэх болно. Ихэнхдээ аз жаргалгүй, зовлон зүдгүүртэй байдаг энэ дэлхийд та найдвар хийгээд амьдралын зорилгыг мэдрэх болно.

*Е*сүс Христийн сайн мэдээ бол
амьдралын зам мөн.

*“Та нар найдварын төгс гэрэлтэйгээр,
мөн Бурханыг болон бүх хүмүүнийг
хайрлах хайрыг агуулан Христэд
тууштайгаар итгэн урагш тэмүүлэх
ёстой. Иймийн тул, хэрэв та нар
урагш тэмүүлэн, Христийн үгнээс
зооглон, мөн эцсээ хүртэл тэвчих
аваас, болгоогтун, Эцэгийн тийн
хэлсэнчлэн: та нарт мөнхийн
амьдрал байх болно.”*

2 Нифай 31:20



БИ ЯАЖ МЭДЭХ ВЭ?

Бошиглогч Иосеф Смит болон бусад бошиглогчдод өгсөн Бурханы илчлэлтүүдээр дамжин Есүс Христийн сайн мэдээ сэргээгдсэн билээ.

Тэнгэрлэг Эцэгээсээ залбирч асууснаар та эдгээр зүйлс үнэн гэдгийг мэдэж чадна. Бурханы Сүнс хэмээн түүнчлэн нэрлэдэг Ариун Сүнсээр дамжуулан Тэрээр танд хариулах болно. Ариун Сүнс Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийг гэрчилж мөн гэрч болдог. Ариун Сүнс мэдрэмж, бодол, сэтгэл хөдлөлөөр дамжуулан үнэнийг илчилж мөн баталж өгдөг. Ариун Сүнснээс ирдэг мэдрэмжүүд нь хүчирхэг боловч түүнчлэн тэдгээр нь ихэнхдээ намуухан зөөлөн байдаг. Библид зааснаар, “Сүнсний үр жимс нь хайр, баяр баясгалан, амар тайван, тэвчээр, энэрэл, сайхан сэтгэл, итгэлтэй байдал, дөлгөөн зан, өөрийгөө захирах байдал нь юм” (Галат 5:22–23).

Эдгээр мэдрэмжүүд бол энэ захиас үнэн гэдгийг гэрчлэх Ариун Сүнснээс ирж байгаа баталгаа юм. Дараа нь та Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн Есүс Христийн сайн мэдээний дагуу амьдрах эсэхээ шийдэх хэрэгтэй.

Би Яаж Залбирах Вэ?

- *Тэнгэрлэг Эцэгтээ ханд.*
- *Зүрх сэтгэлийнхээ мэдрэмжүүдийг илэрхийл (талархал, асуултууд, номлогч нарын заасан зүйлс хийгээд Мормоны Ном үнэн эсэхийг батлах хүсэлт гэхчлэн).*
- *Хаалт (“Есүс Христийн нэрээр, амен”).*

ӨВӨРМӨЦ ХЭЛЛЭГҮҮДИЙН ЖАГСААЛТ

Цагаатгал Биднийг Бурхантай нийцүүлэх боломжтой болгосон үйл явдал. Цагаатгах гэдэг нь нүглийн шийтгэлийн төлөө зовж, тэгснээр наманчлагч нүгэлтнүүдээс нүглийн үр нөлөөллүүдийг зайлуулах гэсэн үг юм. Бүх хүн төрөлхтний төлөө төгс Цагаатгал хийх чадвартай ганц хүн бол Есүс Христ байсан. Түүний Цагаатгалд бидний нүглүүдийн төлөө зовж шаналсан Түүний шаналал, Түүний урсгасан цус, Түүний үхэл хийгээд Амилалт багтдаг. Цагаатгалын учир энэ дэлхийд амьдрах хүн бүхэн амилуулагдах болно. Түүнчлэн нүглүүдээсээ өршөөгдөж, Бурхантай үүрд амьдрах арга замыг Цагаатгал бидэнд бий болгож өгсөн юм.

Баптисм Нүглүүдийнхээ өршөөлийг хүлээн авах анхны алхам. Баптисм болон санваарын эрх мэдлээр гүйцэтгэгддэг гишүүний баталгаагаар дамжуулан бид Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд болдог. Баптисм бол усанд умбуулалтаар хийгддэг бөгөөд энэ нь баптисм хүртэж буй хүнийг богино хугацаанд усан дор байлгана гэсэн үг юм. Христийн жишээг дагахад бид бэлэн байгааг баптисм харуулдаг бөгөөд мөн бид Бурхантай гэрээнүүд хийдэг.

Гишүүний баталгаа Хүн Ариун Сүнсийг хүлээн авах арга зам. Баптисмын дараа, ихэнхдээ ариун ёслолын цуглааны үеэр болдог. Энэхүү ёслолоор хүн гишүүнээр батлагдаж, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн болдог.

Гэрээ Бурхан хийгээд Түүний хүүхдүүдийн дунд хийгдсэн зөвшилцөл. Гэрээний нөхцлийг Бурхан өгч, Түүнийг дуулгавартай дагахаар бид хүлээн зөвшөөрдөг. Бидний дуулгавартай байдлын дагуу өгөхөөр тодорхой адислалуудыг Бурхан амладаг.

Ач ивээл Есүс Христийн нигүүлсэл хийгээд хайраар дамжин өгөгдсөн бурханлиг тусламж болон хүч чадал. Түүний ач ивээлээр дамжин, Цагаатгал боломжтой болгосны дагуу бүх хүн төрөлхтөн амилуулагдах болно. Түүний ач ивээлээр дамжин, наманчилж, Түүний сайн мэдээний дагуу цааш амьдарсаар байх хүмүүс энэ амьдралдаа Тэнгэрлэг Эцэгтээ илүү ойртох мэдрэмжийг мэдэрч, энэ амьдарлын дараа Түүний дэргэд амьдрах болно.

Ёслол Санваарын эрх мэдлээр гүйцэтгэгддэг нандин, онцгой үйлдэл. Жишээ нь, баптисм, Ариун Сүнснийг хүлээн авах, ариун ёслол. Ёслолууд нь ихэвчлэн Бурхантай гэрээ хийх гэсэн утгатай.

Ариун ёслол Сүмийн гишүүдэд Есүс Христийн Цагаатгалыг сануулдаг ёслол. Ариун ёслолоос хүртсэнээр бид баптисмаар хийсэн гэрээнүүдээ шинэчилдэг. Талх усыг адисалж, оролцогчдод өгдөг. Талх нь Есүс Христийн биеийг төлөөлдөг бол ус нь Түүний цусыг төлөөлдөг. Энэхүү ёслол нь долоо хоног бүр ариун ёслолын цуглаан хэмээх бишрэн шүтэх үйлчлэл дээр хийгддэг.

Аврал Нүгэл хийгээд үхлээс чөлөөлөх явц. Аврал нь Есүс Христийн Цагаатгалаар боломжтой болсон юм. Есүс Христийн Амилалтаар дамжин хүн бүр үхлийн нөлөөллийг ялах болно. Түүнчлэн Есүс Христэд итгэсэнээр бид нүглийн нөлөөллөөс аврагдаж чадна. Энэхүү итгэл нь Христэд үйлчилж, сайн мэдээний хуулиуд хийгээд ёслолуудад дуулгавартай байдаг наманчлагчийн амьдралд илрэн гардаг.

НЭМЭЛТ СУРАХ ЗҮЙЛС

Дараах асуултууд болон судрууд нь энэхүү товхимол дээрх зарчмуудын талаар сурч, энэ талаар тунгаан бодоход тань танд туслах болно. Энэхүү жагсаалт нь бүрэн бус юм; судар дахь зүүвэр тайлбар, харьцуулах ишлэлүүд нь нэмэлт захиасууд хийгээд эх сурвалжууд уруу таныг чиглүүлэх болно.

Есүс Христийн сайн мэдээ гэж юу вэ?

3 Нифай 27:13–22 (Мормоны Ном, хуудас 584 (459–60))

Итгэлтэй байх гэдэг нь юу гэсэн үг вэ?

Итгэл танд хэрхэн хүч чадлыг өгч чадах вэ?

Еврей 11:1, 6 (Библи, Шинэ Гэрээ)

Алма 32:21, 26–28 (Мормоны Ном, хуудас 360, 361 (289–90))

Ифер 12:6 (Мормоны Ном, хуудас 649 (509))

Наманчлах гэдэг нь юу гэсэн үг вэ?

Яагаад хүн бүхэн наманчлах хэрэгтэй вэ?

Лук 15:3–10 (Библи, Шинэ Гэрээ)

Үйлс 3:19 (Библи, Шинэ Гэрээ)

Алма 12:33–34 (Мормоны Ном, хуудас 295 (240))

Яагаад хүн бүхэн баптисм хүртэх хэрэгтэй вэ?

Үйлс 2:38 (Библи, Шинэ Гэрээ)

2 Нифай 31–32 (Мормоны Ном, хуудас 135-138 (112–16))

Ариун Сүнс гэж юу вэ?

Ариун Сүнс таны амьдарлыг яаж адисалж чадах вэ?

2 Нифай 32:5 (Мормоны Ном, хуудас 137 (115))

3 Нифай 27:20 (Мормоны Ном, хуудас 584 (459))

Ариун ёслолын зорилго юу вэ?

3 Нифай 18:1–12 (Мормоны Ном, хуудас 563 (442))

Моронай 4–5 (Мормоны ном, хуудас 662–663 (519–20))

Эцсээ хүртэл тэвчих гэдэг нь юу гэсэн үг вэ?

2 Нифай 31:15–20 (Мормоны Ном, хуудас 136 (114))

3 Нифай 15:9 (Мормоны Ном, хуудас 557 (437))

БИДЭНТЭЙ ХАМТ БИШРЭН ШҮТ

СЭРГЭЭГДСЭН САЙН МЭДЭЭ АМЬДРАЛЫГ ТАНЬ
ЯАЖ ӨӨРЧИЛЖ ЧАДАХЫГ ХҮРЧ ИРЭЭД ҮЗ



Ариун ёслолын цуглаан бол хамгийн гол бишрэн шүтэх үйлчлэл юм. Энэ нь ихэвчлэн цаг гаруй үргэлжилдэг бөгөөд ерөнхийдөө дараах үйл ажиллагаануудаас бүрддэг:

Дуулал: Оролцогчид бүгдээрээ дуулдаг. (Дууллын номыг цаанаас хангадаг.)

Залбирлууд: Жирийн Сүмийн гишүүд залбирдаг

Ариун ёслол: Есүс Христийн Цагаатгалыг дурсан санахын тулд талх, усыг адисалж оролцогчдод түгээдэг.

Үг хэлэгчид: Ихэнхдээ оролцогчдоос өмнө нь үүрэг болгосон нэг эсвэл хоёр гишүүн сайн мэдээний сэдвээр үг хэлдэг.

Хувцаслалт: Эрэгтэй хүмүүс болон хөвгүүд бүгдээрээ костюм мөн цамц өмсөж зангиа зүүдэг. Эмэгтэйчүүд болон охид даашинз эсвэл банзал өмсдөг.

Бишрэн шүтэх үйлчлэлийн үеэр өргөл өгөх хүсэлт тавьдаггүй.

Өөрийн сонирхол хийгээд насны дагуу өөр бусад цуглаануудад оролцохыг бид танаас хүсэж байна. Эдгээр цуглаануудын дараалал хийгээд оролцох боломж хоорондоо ялгаатай.

Ням гарагийн хичээл: Судрууд болон сайн мэдээний сургаалуудыг судлахад зориулсан ангиуд.

Санваарын цуглаанууд: 12-оос дээш насны хөвгүүд болон эрэгтэйчүүдэд зориулсан ангиуд.

Нийгмийн Халамжийн Бүлэг: 18 болон түүнээс дээш насны эмэгтэйчүүдэд зориулсан ангиуд.

Залуу Эмэгтэйчүүд: 12-оос 18 насны охидод зориулсан ангиуд.

Хүүхдийн хэсэг: 3-аас 11 насны хүүхдүүдэд зориулсан үйлчлэл хийгээд ангиуд. 18 сартайгаас 3 нас хүртэлх насны хүүхдүүдэд зориулсан хүүхэд харах өрөө ихэнхдээ боломжтой байдаг.



Ариун ёслолын цуглааны цаг: _____

Сүмийн байрны хаяг: _____

Би Юу Хийх Ёстой Вэ?



- *Мормоны Ном унш.*

Уншихаар санал

болгосон судрууд: _____

- *Есүс Христ таны Аврагч мөн гэдгийг мэдэхийн тулд залбир.*

- *Өөртөө нигүүлсэлийг олохоор залбиран мөн наманчил.*
Бурханы зарлигуудын дагуу амьдрахаар хичээгтүн.

- *Сүмд ир.*

- _____ *ний өдөр баптисм хүртэхэд бэлтгэ*

- *Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний талаар илүү ихийг сурч мэдэхийн тулд www.mormon.org гэсэн хаягаар орж үз.*

- *Орчин үеийн бошиглогчдоор дамжуулан Бурханы сэргээсэн үнэнүүдийн талаар илүү ихийг сурч мэдэхийн тулд номлогч нартай үргэлжлүүлэн уулз.*

Дараачийн уулзалтын цаг: _____

Номлогчдын нэрс ба утасны дугаар:

ЕСУС ХРИСТИЙН

ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СУМ

www.mormon.org

Зургийн тайлбар

Нүүрэн талын хавтас: Амьд Ус зургаас авсан хэсэг, Симон Дювей. © Simon Dewey. Хуулбарлаж үл болно
Хуудас 2: Уулан Дээрх Номлол, зураас авсан хэсэг, Карл Хейнрих Блок. Голланд, Хиллеродын Фредериксборгин
Үндэсний Түүхийн Музейн зөвшөөрлөөр ашиглав
Хуудас 5: Христ Иарын охиныг үзлээс босгож байгаа нь, Грег К. Олсен. © Greg K. Olsen
Хуудас 6: The Gentle Healer, by Greg K. Olsen. © Conceptions Unlimited Investments, Inc. Хуулбарлаж үл болно
Хуудас 8: Иохан Баптист Есүст баптисм хүртээж байгаа нь, Грег К.Олсен. © Greg K. Olsen. Хуулбарлаж үл болно.
Хуудас 12, 16, 22, 23: Shih-Yue Huang

MONGOLIAN



4 02011 82363 8

01182 363